



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 02 сарын 07 өдөр

Дугаар 38

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Монголын төмөр зам” төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй нийт 19,829,500.00 (арван есөн сая найман зуун хорин есөн мянга таван зуун) төгрөгийн балансын үнэ, 3,492,924.00 (гурван сая дөрвөн зуун ерэн хоёр мянга есөн зуун хорин дөрвөн) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан автомашиныг Баянзүрх дүүргийн прокурорын газарт балансаас балансад шилжүүлсүгэй.

2. “Монголын төмөр зам” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Б.Цэнгэл, Баянзүрх дүүргийн прокурорын газрын ерөнхий прокурор, хууль цаазын итгэмжит зөвлөх Ц.Батболд нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг дэалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор үндсэн хөрөнгийг шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;


2.2. Хөрөнгийн хөдлөлийг зсхих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн дотор Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛТЭСИЙН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙН
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ




Ц.НЯМ-ОСОР

Э.ЭРДЭНЭХИШИГ

D:\Huraldaanii material\2018.02.07\togtool\03docx

0001405

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
 2018 оны 02 дугаар сарын 24-ны өдрийн
 3 д. дугаар тогтоолын хавсралт



"Монголын төмөр зам" төрийн өмчит хувьцаат компанийн балансаас Баянзүрх дүүргийн прокурорын газрын
 балансад шилжүүлэх автомашин

Д/д	Хөрөнгийн нэр, Улсын дугаар, Арлын дугаар	Үйлдвэрлэсэн, ашиглалтад орсон он	Нийт гүйлт (км)	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэх өртөг (төгрөг)
1	Тоёота Приус-30, Суудлын автомашин, 51-00 УНЯ улсын дугаартай, ZVW301854491 арлын дугаартай.	2014/2015	49,232	19,829,500.00	3,492,924.00	16,336,576.00
Нийт дүн				19,829,500.00	3,492,924.00	16,336,576.00
				(арван есөн сая найман зуун хорин есөн мянга таван зуун)	(гурван сая дөрвөн зуун ерэн хоёр мянга есөн зуун хорин дөрвөн)	(арван зургаан сая гурван зуун гучин зургаан мянга таван зуун далан зургаан)